

Сонин содон үг хэллэг, тэмдэг нэр, мэдрэмж
сэтгэгдэл оруулан, гадаад дотоод шинжийг
тоочин дүрсэлж хөрөг бичих

7-р анги

Дүрслэлүүдийг дахин эргэцүүлэн бодъё

- ✦ хэвлэх цехэд өглөөнөөс орой хүртэл ажиллаж
- ✦ шөнийн цагаар ном уншиж, бичгийн чадвараа дээшлүүлж
- ✦ олдсон жаахан мөнгөө ном худалдаж авахад зориулдаг
- ✦ цорын ганц амралт нь уншлагын цаг

- ✦ дорно зүгийн тансаг мэдрэмж, гүн ухаанаар нэвчиж
- ✦ байгальтайгаа ширэлдсэн уягдсан шүлгүүд
- ✦ өр зөөлөн хүн

- ✦ навсгар жаахан элбэгдсэн дээл томдсон гутал
- ✦ модоор зорсон монгол шатрын ноёнорхуу бас ч хэвлүү....
- ✦ буузгар хүн
- ✦ хонины муухан мөлжсөн тойгорхуу
- ✦ шазуураа зууж ярих
- ✦ эззгий үмхчихсэн юм шиг
- ✦ нэг хацар нь бумбайж
- ✦ ярих гэж удаан, зуурч өгнө

- ✦ гүдэсхэн зангаар театрынхаа хаалгыг хааж
- ✦ нүд дүүрэн эмэгтэй товор товор алхлан
- ✦ арилж баларшгүй томоос том орон зайг эзэлсэн
- ✦ борооны дараах солонго шиг төрсөн
- ✦ ихэмсэг инээмсэглэл уруул дээрээ тодруулсан
- ✦ хээ шаагүй, атаа жөтөөгүй, алдаж онохоос сийхгүй
- ✦ тэр аяглаж, аргалж, захалж, эрхэлж туулсангүй
- ✦ алдсан шиг алдаж, оносон шиг онож явсан

Бичигч тухайн хүнээ одоо цаг хугацаанд байгаагаар нь эсвэл өнгөрсөн цаг үед байсныг дурссан зэргээр өөр өөр орон зай, цаг хугацаанаас хамаарч тэр хүнийхээ дүрийг илүү тод гаргахын тулд тухайн хүнийхээ давтагдашгүй эрхэм сайхан чанарууд, хийж бүтээсэн зүйл, амжилт, авьяас чадвар, хүсэл мөрөөдөл зэрэг онцлогийг гаргах, түүгээрээ уншигчдын сэтгэл зүрхэнд хүрэхийн тулд шинэ мэдээлэл, сонин содон дүрслэл оруулж бичдэг.

А,Б эхийн хэсгээс уншаад ,сонин содон үг хэллэгийг бичье

А

Л.Түдэвийн аав С.Лодон Говь-Алтай аймгийн Наран сум, аймаг, улсдаа алдартай уран гарт “нарийн” мужаан, дархан хүн байжээ. Аав нь хүүдээ цуурга цоожтой модон цүнх урлаж өгөөд эрдмийн их аянд мордуулсан нь “Номын сав бүтэн байхын” билиг ерөөл байсан аж. С.Лодон мужаан хэзээний төлөв төвшин, дуу цөөтэй, ажлын төлөө нойр хоолгүй зүтгэдэг гүндүүгүй сайхан эр байсныг нутгийн мужаан О.Туваанжав дурсан ярьдаг байжээ. Ээж Н.Цаян нь нутгийнхандаа Жүүжээ хэмээн авгайлагддаг, орсон гарсан хүмүүсийг дайлж цайлж хуучилсан сайхан ааш зантай монгол эмэгтэй байв. Үг-77

А.

- Уран гарт “нарийн “ мужаан, дархан хүн
- Ажлын төлөө нойр хоолгүй зүтгэдэг
- гүндүүгүй сайхан эр
- Жүүжээ хэмээн авгайлагддаг
- Дайлж, цайлсан

Б.

- Өөрийн “ би”- г олсон төгс эрхэмсэг хүн
- Бэх үнэртсэн гартай бичиг номын хүн
- Түдэв маягийн аж төрөх ёс
- Их унших, гүн сэтгэх
- Цагийг цагийн механизм шиг ашиглах
- Дэл сул занг үл таашаах
- Хариу нэхэхгүй тусч сэтгэлээр хандах
- Холч мэргэнээр угтан харах
- Цаг мөч бүртэй уралдан

Б

ӨӨРИЙН “БИ”-Г ОЛСОН ТӨГС ЭРХЭМСЭГ ХҮН

Л.Түдэв бол бэх үнэртсэн гартай бичиг номын хүн. СГЗ Х.Цэвлээгийн тодорхойлсноор, Түдэв маягийн аж төрөх ёс гэж түүнд бий. “Их унших, гүн сэтгэх, бүтээлч ажиллах, цаг хугацааг цагийн механизм шиг ашиглах, аливаа дэл сул занг үл таашаах, хүмүүст хариу нэхэхгүй тусч сэтгэлээр хандах, үзэл бодолдоо үнэнч байх, холч мэргэнээр угтан харах”.

Ийм зарчим, ийм хэмнэлээр цаг мөч бүртэй уралдан үр бүтээлтэй ажиллаж ирсэн учир тэрбээр энэ их амжилтад хүрчээ. Түүний амжилт ололт, бүтээж туурвисан бүхнээс сэтгүүл зүйн бүтээлүүдийг нь анхлан онцлохыг зорьж буй тул баримт эш татъя.

“...Би сэтгүүл зүйн төрлүүд дотроос асуудал дэвшүүлсэн нийтлэлийг голчлон сонгож авсан. Сүүлд нь түүнийг иссэн бодлын ханд буюу эсээ маягт оруулаад онцгой чухал гэж бодсон асуудал бүрээр бичиж байсан болохоор нийгмийн анхааралд хүргэх ёстой юмаа хэлсээр тул харамсах юм уу төсөөлөл зөрсөн зүйл байхгүй. Харин харамсах зүйл бол нэгэнт байгааг нь нотлоод дэвшүүлчихсэн асуудлыг шийдвэрлэх эрмэлзэл улс төрчдөд их дутаж байсан, одоо бүр ч унтарч байх шив дээ!” хэмээн Л.Түдэв ярилцлагадаа хэлсэн байдаг.

Уран дүрслэлийг ямар зорилгоор хэрэглэсэн бэ?

- Хонины муухан мөлжсөн тойгорхуу хоовон толгойтой

жижигхэн, гонзгойдуу хэлбэртэй толгойг тойгтой адилтгасан .

- Навсгар жаахан Манжаа элбэгдсэн дээл, томдсон гуталтайгаа зогсож байх нь модоор зорсон монгол шатрын ноёнорхуу бас ч хэвлүү

Манжаагийн элбэгдсэн дээл, томдсон гуталтай гэсэн гадаад дүр төрхийг илүү тодруулж, жижигхэн биетэй ч тэрүүхэндээ ихэрхэг зан байдалтайг нь шатрын ноёнттой адилтгасан.

Уран дүрслэлийг ямар зорилгоор хэрэглэсэн бэ?

- Аав нь гээд тавь нэлээн гарсан, нар салхинд **онгож гандсан, хүрэл шиг** хүрэн бор царайтай, **шавилхан биетэй**, хөнгөн шингэн гэж жигтэйхэн, жижигхэн гялалзуур өвгөн байлаа.
- Эцсэн шар хөллөсөн тэрэгний дугуй шиг **энхэн донхон дайвалзан**, залхуутай эргэх, эгэл жир гунигт бор өдрүүд.
- Надаас авах юм юу байх вэ. **Адайр зан, адсага шиг** хөх царай, **хавчиг хар** толгой.
- Адуу **морьд шигээ омголон**, **хийморьтой** эр явлаа.

Тухайн хүний зан ааш, сэтгэлийн онцлог, ажил үйлсийн гайхалтай бишрэм байдлыг илүү тодруулах, уншигчийн сонирхлыг татахын тулд уран дүрслэл ашиглан бичдэг.

Хэн нэгэн хүний гадаад дотоод шинжийг тоочин дүрсэлж бичье



Дүрслэл	Гадаад шинж	Дүрслэл	Дотоод шинж
Нүүр царай	Хөрслөг бор царайтай , өтгөн хөмсөгтэй, яралзсан цагаан шүдтэй, шулуун шударга, угсал зөөлөн харцтай, насандаа ахадсан гэмээр буурь заасан төрхтэй хүн	Ааш зан	Хэлэх гэсэн зүйлээ шулуун шударга хэлдэг, гүндүүгүй сайхан ертөнц
Бие галбир	Өндөрдүү нуруу, өргөн цээж, спортоор тууштай хичээллэдэг болов уу гэмээр шөрмөслөг байрын биетэй	Давтагд ашгүй чанар	Өөртөө итгэлтэй , зарчимч ,эзэмшсэн мэргэжилдээ эзэн нь байж чаддаг, бусдад хүндэтгэлтэй ханддаг.
Хувцаслалт	Ихэвчлэн жинсэн өмд, бараандуу өнгийн цамцыг хослуулна, ажил хэрэгч хувцасыг өдрийн од шиг өмсдөг.	Үзэл бодол	Хэрвээ жүжигчин гэх алдрыг зүүж яваа бол урлагийг хүндэтгэх ёстой гэж үздэг.
Алхаа гишгээ	Ялимгүй бөгтийж явдаг	Яриа хөөрөө	Энгийн ярих, хэлэх гэсэн зүйлээ оновчтой цөөн үгээр илэрхийлдэг.

Хөрөг найруулал

Сонгосон баатрынхаа амьдралын замнал, давтагдашгүй онцлог, зан төрх, ололт амжилт, саад бэрхшээлийг даван туулсан туршлага, үзэл бодол, хүсэл сонирхол, гадаад байдал, хэл яриа зэрэг нь уншигчдад шинэ мэдээлэл, сонин содон санаа болж байдаг тул эдгээр шинжид анхаарлаа төвлөрүүлж онцлон бичнэ.

Гадаад дотоод шинжийг тоочин бичих

Ямар асуудлын тухай бичих вэ?

Үүний талаар хэн, хэн илүү чухлыг хэлэх бол?

Тэдний хэнтэй нь уулзаж энэ тухай бичих вэ?

Уншигчдад сонирхолтой болгохын тулд сонин содон үг хэллэг, тэмдэг нэр яаж оруулах вэ?

Энэ хүний тухай яаж бичих вэ? (дүр төрх, зан ааш, ажил үйл, амжилт бүтээл)

Бусад хүнээс юуг тодруулах, ямар мэдээ, баримт цуглуулах вэ?

Ямар бүтэц, дараалалтай бичих вэ?

1. Төлөвлөгөө зохиох



2. Дүрслэн бичихийн тулд бичих бүтцээ төлөвлөх

Эхлэл	Гол	Төгсгөл
Сонирхолтой эхлэлийг яаж гаргах вэ? <i>Б.Ганчимэгийн бичсэн хөрөг яаж эхэлснийг саная</i>	Гадаад байдал, дүр төрх, зан аашийг яаж тоочин дүрсэлж бичихээ жагсааж үзье. Жагсааснаа найруулж сонин содон үг хэллэг, дүрслэл оруулж бичье. Сэтгэгдэл мэдрэмжээ оруулж бичье	Өөрийн дүгнэлтээ оруулж бичье.

Хэн нэгний тухай бичихийн тулд:

- ✦ Энэ сэдэв (асуудал) чиний хувьд яагаад чухал байв ?
- ✦ Энэ сэдвийн талаар чи хэр мэдлэгтэй вэ?
- ✦ Энэ талаар ямар хүнтэй уулзаж юуг асууж тодруулан бичих вэ?
- ✦ Уншигчид юуг ойлгоосой гэж хүсэж байна? гэдгээ эргэцүүлье.

3. Бичих сэдэв ямар байж болох вэ? Ямар хүний тухай бичих вэ?

- Байгаль орчноо хамгаалах
- Бусдын төлөө сэтгэлээ зориулах
- Спорт, урлагийн амжилтад хүрэх
- Мал сүргээ өсгөх
- Шинийг санаачлах гэх мэт

4. Бичих сэдвийн хүрээнд судалгаа хийж, баримт цуглуулах



5. Бичих төлөвлөгөө гаргах , гарчиг өгөх

Зүүд биш ээ	Инфляц галзуурах цагаар (Л.Болормаа)	
Их хааныг хилэгнүүлсэн байх аа. (Л.Эрдэнэбулган)	Эглээс эгэл	
Үйлс заяаны зам	Биднийг хэн тэжээдэг вэ? (Б.Баабар)	
Малын тоосонд өссөн хүн	Хэнээт	Сүүдэр дайрахад ч
Үргэлжлэлтэй зам.	Хөх зүрхний зураас (Б.Баабар)	Чулуу эмэнд ордог эрдэнэ (Ж.Оюун)

Бичих алхам

- Бичих сэдвээ сонгох
- Баримт мэдээлэл цуглуулах, сонгох
- Бүтцээ гаргах
- Зохиомжоо бодож, төлөвлөх
- Бичих

6. Бичвэрээ хэдэн цогцолборт багтаан бичих вэ? Эхлэл, гол, төгсгөл хэсэгт яаж хуваарилах вэ? Агуулга ямар байх вэ?

Эхлэл хэсэг

- ★ Яаж эхлэх вэ? (асуултаар уу, сонирхолтой жишээгээр үү, өөрийн эргэцүүлээр үү)
- ★ Эхлэлээ юугаар дэмжих вэ? (бусдын яриа, жишээ баримт, тэр хүний бүтээл, амжилтын баримтаар уу, бусдын хэлсэн үгээр үү гэх мэт)

Гол хэсэг



Төгсгөл хэсэг

Мэдрэмж, сэтгэгдэл оруулах уу?

Дүгнэх үү?

7. а.Төлөвлөсний дагуу бичих

Бичихдээ юуг анхаарах вэ?

- Нийгэмд хэрэгтэй зүйлийг нь тодорхой гаргах
- Тэр хүний хувийн онцлогийг гаргахдаа судалгаа хийсэн, цуглуулсан баримт, мэдээллээсээ оновчтой, тохиромжтойг нь сонгон оруулах
- Тэр хүнийг танихгүй мэдэхгүй , үзээгүй хүмүүсийн нүдэнд харагдтал гадаад төрхийг нь дүрслэн гаргах
- Тэр хүний зан ааш, сэтгэлийн мөн чанарыг бусдад дуурайл болохоор дүрслэн бичих

Б. Бичсэнээ засан сайжруулах

- Төлөвлөсөн зүйлээ бүгдийг оруулсан уу?
- Эхлэл, гол, төгсгөл хэсэг тодорхой болж уу?
- Хүмүүс уншихад сонирхолтой байна уу?
- Уншсан хүнд хэрэгтэй чухал мэдээлэл байна уу?

В. Дахин сайжруулж уншъя

- Өгүүлбэрийн төгсгөлүүд өнгөрсөн цагт байна уу?
- Үйл явдлууд зэрэгцэж болсныг зөв холбож уу?
- Сонин содон үг хэллэг, тэмдэг нэр оруулж бичсэн үү?
- Уншсан хүнд хэрэгтэй чухал мэдээлэл байна уу?

Шалгуур

- Бүтцийн хэсгүүдээ догол мөрөөр илэрхийлсэн үү?
- Дүрийнхээ гадаад , дотоод шинжийг сэтгэлд буутал тоочин дүрсэлж бичсэн үү?
- Онцлог шинжийг бичихдээ тэмдэг нэр ашигласан уу?
- Онцлог шинжийг дүрслэхдээ дүрслэх ур маяг ашигласан уу?
- Сэтгэлийн өнгө аясаа илэрхийлж чадсан уу?
- Найруулгын болоод зөв бичихийн дүрмийн алдаагүй юу?